

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 7 сарын 31-ний өдөр

Дугаар: 20/02

Улаанбаатар хот

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалт 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдрөөс 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн төв оффис болох Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Холдингсын байр, 2 давхарт хүлээн авав.

Эчнээ санал хураалтад оролцсон хувьцаа эзэмшигчид: 59.4%

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх дүгнэлт хийснээр: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн нийт хувьцааны тоо 28,614,263 ширхэг хувьцаа байгаагаас 11,920,930 ширхэг хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр болон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтад оролцов. Эдгээр хувьцааны тоонд 8,543,936 ширхэг саналын эрхгүй хувьцаа байгаа бөгөөд нийт саналын эрхтэй 20,070,327 ширхэг буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 70.1 хувь нь санал өгөх эрхтэй болно гэж тооллогын комиссын дарга дүгнэв. Үүнээс 11,920,930 ширхэг хувьцаа эзэмшигчид санал өгч, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 59.4 хувь санал хураалтад оролцсон тул Компанийн тухай хуулийн 73 дүгээр зүйлийн 73.7 дэх заалт, Компанийн дүрмийн 7.13-ыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтыг хүчин төгөлдөрт тооцов.

Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай;

Хэлэлцсэн нь №1: Ард Санхүүгийн ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай.

Санал хураалтыг 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдрөөс 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл явуулав.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

Тооллогын комиссын шийдвэр:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай асуудлаар:

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд эчнээ саналын хуудсаар ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн “Дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг батлах тухай” санал хураалтад 11,920,930 ширхэг буюу 59.4 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 1. Зөвшөөрсөн 11,920,930 ширхэг буюу 100 %;
 2. Татгалзсан 0 ширхэг 0 %;
 3. Түдгэлзсэн 0 ширхэг 0 % байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Хүчингүй болсон саналын хуудасны тоо:
 1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн “Дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг батлах тухай” эчнээ санал хураалтад хүчингүй болсон саналын хуудас байхгүй болно.

Эчнээ санал хураалтын шийдвэр:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга П.Батбаяр: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны эчнээ санал хураалтаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

Ард Санхүүгийн ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлав.

ХЯНАСАН:
Хурлын дарга



Ч.Ганхуяг

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
Төлөөлөн удирдах зөвлөлийн
нарийн бичгийн дарга

A handwritten signature in black ink, likely belonging to the Chairman of the Board of Directors.

Х.Хулан